НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2023/05/НА-СТА-ТТ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn<br>Аудитын менежер:Я.Алтанцэцэг<br>Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Ундармаа<br>Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn<br>Аудитор: Д.Нарантуяа<br>Утас: 325093 Цахим хаяг: narantuyad@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт ........ 4
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ........ 7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ........ 8
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 10
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ... 17
3.4.1 Мөнгөн хөрөнгө ........ 18
3.4.2 Авлага ........ 19
3.4.3 Урьдчилгаа ........ 19
3.4.4 Бараа материал ........ 19
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө ........ 20
3.4.6 Үндсэн хөрөнгө ........ 20
3.4.7 Өр төлбөр ........ 22
3.4.8 Засгийн газрын хувь оролцоо ........ 22
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 23
3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 23
3.5.2. Дүүргийн төсвийн орлого бүрдүүлалт ........ 23
3.5.3 Төсвийн гүйцэтгэл ........ 25
3.5.4 Нэмэлт төсөв ........ 26
3.5.5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт ........ 26
3.5.6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ....... 27
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 28
4.1 Ерөнхий зүйл ........ 28
4.2 Материаллаг байдал ........ 28
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 28
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...... 29

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 29
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .......... 30
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 30
4.5.1 Завсрын аудитын талаар .......... 30
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .......... 30
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 31
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... 32
5.1 Төлбөрийн акт..........
5.2 Албан шаардлага..........
5.3 Зөвлөмж..........
5.1.1. Орон нутгийн байгууллага .......... 33
1.Төлбөрийн акт.......... 33
2 Албан шаардлага .......... 33
5.1.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд .......... 34
1.Төлбөрийн акт.......... 34
2.Албан шаардлага .......... 34
3. Зөвлөмж .......... 35
5.3 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүн.......... 35
3.Зөвлөмж.......... 35-37
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.......... 38-40

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| МУЗГ | Монгол Улсын засгийн газар |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗД | Засаг дарга |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| МУЗЗНДНТУТХ | Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| БТСХ | Биеийн тамир спорт хороо |
| ЖДҮДТ | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв |
| ХААА | Худалдан авах ажиллагааны төв |
| ДАА | Дотоод аудитын алба |
| ГБХЗХХ | Гэр бүл,хүүхэд залуучуудын хөгжлийн жил |
| ОНӨААН | Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 64,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 05. 24 № 850

танай ______ -ны № ______

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
А.СҮХБОЛД ТАНАА

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Багахангай дүүргийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус дүүрэг нь 2022 онд бүтцийн өөрчлөлтөөр 5 (*Хангай цогцолбор сургууль, 44 дүгээр цэцэрлэг, 207 дугаар цэцэрлэг, ГБХЗХХ, БТСХороо*) байгууллагын үлдэгдлийг улсын төсөвт шилжүүлснийг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

## Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дүүргийн засаг дарга Нийслэлийн Засаг даргатай хийсэн гэрээгээр төлөвлөн хэрэгжүүлэх эрх, үүргийн хүрээнд 29, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5, гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээ дүгнэх 3, нийт 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 97.4 хувьтай ажиллажээ. Байгуулсан гэрээний биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээгээр 88.3 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан,төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,778,913.90** | **1,422,174.80** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 1,081,057.20 | 751,018.00 |
| 33 | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 76,455.80 | 55,454.30 |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | 7а, 7б | 2,581.40 | 14,919.10 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 618,819.50 | 600,783.40 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **15,831,353.70** | **13,700,621.60** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 15,831,353.70 | 13,700,621.60 |
| 39200 | **Биет хөрөнгө** | | 15,606,394.90 | 13,460,795.80 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 13 | 224,958.80 | 239,825.80 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **17,610,267.60** | **15,122,796.30** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 47,420.80 | 56,091.40 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 47,420.80 | 56,091.40 |
| 41300 | **Өглөг** | 17а, 17б | 46,177.80 | 55,772.10 |
| 41400 | **Урьдчилж орсон орлого** | 18а, 18б | 1,243.00 | 319.3 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **17,562,846.80** | **15,066,704.90** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | | 17,562,846.80 | 15,066,704.90 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 4,114,642.80 | 2,115,911.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | 4,114,642.80 | 2,115,911.00 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 4,996,866.10 | 6,441,015.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 133,425.60 | 162,060.10 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | | 2,746,333.70 | 2,848,254.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 5,571,578.60 | 3,499,464.20 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **17,610,267.60** | **15,122,796.30** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **9,391,091.60** | **8,567,731.00** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | **143,767.40** | **995,177.30** |
| 110 | Орлогын албан татвар | | 84,676.90 | 879,786.50 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 84,676.90 | 879,786.50 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 936 | 34,967.40 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 58,154.50 | 80,423.40 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1а, 1б | **4,478,532.70** | **3,614,786.20** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | | 2,750,631.90 | 3,371,436.40 |
| 123 | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | | 1,727,900.80 | 243,349.90 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **4,768,791.40** | **3,957,767.40** |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2а, 2б | **8,731,745.10** | **7,149,473.80** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **8,731,745.10** | **7,149,473.80** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **7,260,408.60** | **5,519,863.60** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 3,218,430.90 | 1,627,521.40 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 410,599.60 | 202,521.60 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 407,193.40 | 431,931.30 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | | 126,086.40 | 104,490.90 |
| 2105 | **Норматив зардал** | | 27,796.00 | 0 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 38,156.80 | 48,053.80 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | | 17,663.00 | 19,452.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 758,908.70 | 1,162,435.10 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 2,255,573.70 | 1,923,457.60 |
| 212 | **ТАТААС** | | 1,407,035.50 | 1,543,189.40 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **64,301.00** | **86,420.80** |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **659,346.50** | **1,418,257.20** |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **743,748.30** | **5,380,457.60** |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | **-84,401.70** | **-3,962,200.40** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **9,183,107.15** | **5,576,608.96** | **2,823,378.41** | **17,583,094.52** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 7,357.01 | 7,357.01 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,183,107.15 | 5,576,608.96 | 2,830,735.42 | 17,590,451.53 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -5,030.40 | 0.00 | -5,030.40 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 61,827.40 | 0.00 | 0.00 | 61,827.40 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -84,401.74 | -84,401.74 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **9,244,934.55** | **5,571,578.55** | **2,746,333.67** | **17,562,846.78** |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **9,244,934.55** | **5,571,578.55** | **2,746,333.67** | **17,562,846.78** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -1,484,003.72 | -1,740,864.54 | -412,917.15 | -3,637,785.41 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **7,760,930.83** | **3,830,714.02** | **2,333,416.52** | **13,925,061.37** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -514,728.10 | -326,696.50 | -473,829.24 | -1,315,253.84 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | -4,553.28 | 0.00 | -4,553.28 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 1,472,783.35 | 0.00 | -641.72 | -1,472,141.64 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -3,962,200.40 | -3,962,200.40 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **8,718,986.08** | **3,499,464.23** | **2,848,254.57** | **150,066,704.88** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | **9,485,663.00** | **7,934,499.30** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | **143,767.40** | **995,177.30** |
| 110 | Орлогын албан татвар | | 84,676.90 | 879,786.50 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 84,676.90 | 879,786.50 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 936 | 34,967.40 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 58,154.50 | 80,423.40 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 29,053.60 | 25,669.60 |
| 1181 | Газрын төлбөр | | 26,584.80 | 52,207.90 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 2,516.10 | 2,546.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **4,565,436.30** | **2,967,422.40** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 2,837,535.50 | 2,724,072.60 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 1,727,900.80 | 243,349.90 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **4,776,459.30** | **3,971,899.50** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **8,751,180.90** | **7,793,866.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **8,751,180.90** | **7,793,866.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **7,279,035.40** | **5,913,653.10** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 4,144,326.20 | 2,686,694.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 683,366.00 | 503,058.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 624,980.80 | 685,647.20 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 599,320.40 | 877,310.30 |
| 2105 | Нормативт зардал | | 29,226.20 | 4,496.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 46,840.90 | 62,859.70 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 18,688.20 | 31,452.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 533,999.30 | 806,540.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 598,287.40 | 255,593.80 |
| **212** | **ТАТААС** | | **1,407,035.50** | **1,543,189.40** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **65,110.00** | **337,024.20** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | **734,482.20** | **140,632.60** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | **438,279.70** | **470,671.80** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **438,279.70** | **470,671.80** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 438,279.70 | 470,671.80 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | **-438,279.70** | **-470,671.80** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | **296,202.50** | **-330,039.20** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 784,854.70 | 1,081,057.20 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,081,057.20 | 751,018.00 |

## 2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,631,240,800.00** | **5,322,893,013.15** | **308,347,786.85** | **94.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,241,076,300.00** | **4,971,519,926.15** | **269,556,373.85** | **94.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,351,084,900.00** | **3,094,516,293.15** | **256,568,606.85** | **92.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,758,310,500.00** | **1,583,341,701.78** | **174,968,798.22** | **90.0** |
| 210101 | Үндсэн цалин | 1,106,217,100.00 | 1,044,110,319.74 | 62,106,780.26 | 94.4 |
| 210102 | Нэмэгдэл | 326,994,000.00 | 252,674,216.04 | 74,319,783.96 | 77.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 142,355,000.00 | 114,588,790.60 | 27,766,209.40 | 80.5 |
| 210104 | Урамшуулал | 132,784,400.00 | 133,638,358.40 | -853,958.40 | 100.6 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 49,960,000.00 | 38,330,017.00 | 11,629,983.00 | 76.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **236,163,500.00** | **197,527,631.42** | **38,635,868.58** | **83.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 165,529,800.00 | 136,719,882.51 | 28,809,917.49 | 82.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,326,600.00 | 15,658,164.41 | 1,668,435.59 | 90.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,375,200.00 | 12,301,322.50 | 2,073,877.50 | 85.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,704,900.00 | 3,097,158.29 | 607,741.71 | 83.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,227,000.00 | 29,751,103.71 | 5,475,896.29 | 84.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **452,419,100.00** | **430,277,740.32** | **22,141,359.68** | 95.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,258,000.00 | 34,887,504.57 | 10,370,495.43 | 77.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 359,405,700.00 | 353,443,028.00 | 5,962,672.00 | 98.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 44,875,400.00 | 39,067,207.75 | 5,808,192.25 | 87.1 |
| 210304 | Байрны түрээс | 2,880,000.00 | 2,880,000.00 | 0.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **87,761,700.00** | **81,665,565.63** | **6,096,134.37** | 93.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 24,775,000.00 | 23,717,810.00 | 1,057,190.00 | 95.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,740,400.00 | 21,508,900.00 | 231,500.00 | 98.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,376,600.00 | 13,661,710.63 | 2,714,889.37 | 83.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 850,000.00 | 500,000.00 | 350,000.00 | 58.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,536,900.00 | 3,436,480.00 | 100,420.00 | 97.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,482,800.00 | 18,840,665.00 | 1,642,135.00 | 92.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,500,000.00** | **4,496,000.00** | **4,000.00** | 99.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,500,000.00 | 4,496,000.00 | 4,000.00 | 99.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **141,151,700.00** | **139,087,670.00** | **2,064,030.00** | 98.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,600,000.00 | 22,044,500.00 | 555,500.00 | 97.5 |
| 210602 | Тавилга | 8,000,000.00 | 7,176,000.00 | 824,000.00 | 89.7 |
| 210604 | Урсгал засвар | 110,551,700.00 | 109,867,170.00 | 684,530.00 | 99.4 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **32,681,000.00** | **31,452,000.00** | **1,229,000.00** | 96.2 |
| 210701 | Гадаад албан томилолт | 12,000,000.00 | 12,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,681,000.00 | 19,452,000.00 | 1,229,000.00 | 94.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **416,353,600.00** | **406,509,171.00** | **9,844,429.00** | 97.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 408,543,200.00 | 399,743,682.00 | 8,799,518.00 | 97.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,255,000.00 | 775,870.00 | 479,130.00 | 61.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 566,900.00 | 548,752.00 | 18,148.00 | 96.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 255,000.00 | 176,000.00 | 79,000.00 | 69.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,445,500.00 | 1,423,500.00 | 22,000.00 | 98.5 |
| 210807 | Газрын төлбөр | 288,000.00 | 254,367.00 | 33,633.00 | 88.3 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,500,000.00 | 1,087,000.00 | 413,000.00 | 72.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **221,743,800.00** | **220,158,813.00** | **1,584,987.00** | 99.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 215,416,000.00 | 214,158,313.00 | 1,257,687.00 | 99.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,327,800.00 | 6,000,500.00 | 327,300.00 | 94.8 |
| **212** | **ТАТААС** | **1,543,189,400.00** | **1,543,189,400.00** | **0.00** | 100.0 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | **1,543,189,400.00** | **1,543,189,400.00** | **0.00** | 100.0 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 1,543,189,400.00 | 1,543,189,400.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **346,802,000.00** | **333,814,233.00** | **12,987,767.00** | 96.3 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **296,482,000.00** | **284,123,287.00** | **12,358,713.00** | 95.8 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 296,482,000.00 | 284,123,287.00 | 12,358,713.00 | 95.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **50,320,000.00** | **49,690,946.00** | **629,054.00** | 98.7 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,200,000.00 | 4,200,000.00 | 0.00 | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,100,000.00 | 1,976,000.00 | 124,000.00 | 94.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,100,000.00 | 21,081,051.00 | 18,949.00 | 99.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,920,000.00 | 22,433,895.00 | 486,105.00 | 97.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **390,164,500.00** | **351,373,087.00** | **38,791,413.00** | 90.1 |
| 220001 | Барилга байгууламж | 146,164,500.00 | 146,164,500.00 | 0.00 | 100.0 |
| 221001 | Их засвар | 7,000,000.00 | 7,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 87,000,000.00 | 48,208,587.00 | 38,791,413.00 | 55.4 |
| 223001 | Бусад хөрөнгө | 150,000,000.00 | 150,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,631,240,800.00** | **5,335,251,706.15** | **295,989,093.85** | 94.7 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **243,349,900.00** | **257,481,980.00** | **-14,132,080.00** | 105.8 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 243,349,900.00 | 257,481,980.00 | **-14,132,080.00** | 105.8 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **4,778,259,300.00** | **5,061,792,604.15** | **-283,533,304.15** | 105.9 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 4,778,259,300.00 | 5,061,792,604.15 | **-283,533,304.15** | 105.9 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **609,631,600.00** | **15,977,122.00** | **593,654,478.00** | 2.6 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,069,400.00 | 15,977,122.00 | **3,092,278.00** | 83.8 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 590,562,200.00 | 0 | **590,562,200.00** | 0.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 9,491,369.00 | **-9,491,369.00** | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 21,850,062.00 | **-21,850,062.00** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **11** | **11** | **0.00** | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 11 | 11 | **0.00** | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **119** | **111** | **7.00** | 93.3 |
| 620001 | Удирдах ажилтан | 21 | 21 | **0.00** | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 62 | 55 | **7.00** | 88.7 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30 | 29 | **1.00** | 96.7 |
| 620004 | Гэрээт ажилтан | 6 | 6 | **0.00** | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлант он |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **212,385,840.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **212,385,840.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **207,459,383.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **171,424,383.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 171,424,383.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **36,035,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,035,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,926,457.00** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,926,457.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 4,926,457.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **212,385,840.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **212,385,840.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,365,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 203,170,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,850,840.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь *"Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ хийх, Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, захиргааны болон төсөв, татвар, санхүүгийн удирдлага зохион байгуулалтыг хангах, холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх*" гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Дүүргийн иргэдэд төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд төсвийн хөрөнгийн урсгалыг чиглүүлэх;
- Дүүргийн төсвийн орлогын боломжит бүх эх үүсвэрийг дайчлах, татварын ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, татвар хураалтыг эрчимжүүлэх;
- Дүүргийн 2022 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг дүүргийн төсвийн орлогын тогтвортой эх үүсвэртэй уялдуулж, төсвийн зардлыг төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахгүй мөрдөж байгаа төсвийн норм үнэлгээ, үйлчилгээний үнэ тарифыг үндэслэн боловсруулах;
- Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг сайжруулах, дүүргийн хөгжлийн бодлого болон төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангаж, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд тэвчиж болох зардлыг хэмнэх, бууруулах, орон тоог нэмэгдүүлэхгүй байхад анхаарч төлөвлөхдөө төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, мөрдөж байгаа төсвийн норм үнэлгээ, үйлчилгээний үнэ тарифыг үндэслэн тэвчиж болох зардлуудыг багасгах, сул давхардсан орон тоог хасах зэргээр урсгал зардлыг хэмнэх бууруулах;

2022 онд "*Иргэдийн оролцоотой хөгжлийн жил* " зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Дүүргийн засаг дарга Нийслэлийн Засаг даргатай хийсэн гэрээгээр төлөөлөн хэрэгжүүлэх эрх, үүргийн хүрээнд 29, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5, гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээ дүгнэх 3, нийт 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 97.4 хувьтай ажиллажээ. Байгуулсан гэрээний биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээгээр 88.3 хувиар үнэлэгдсэн байна.

2022 оны дүүргийн онцлог үйл явдал арга хэмжээний талаар дурдвал:

- Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 13 байгууллага 16 төрлийн лавлагаа, мэдээллийн үйлчилгээг E-Mongolia системээс үзүүлж байна.
- Төрийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем"-д бүртгэн, цалингийн нэгдсэн системтэй холбон албан хаагчдын цалингийн гүйлгээг цахимаар хийж, Төрийн сангийн газраас нэвтрүүлж буй "ПОРТАЛ СИСТЕМ" –ийг ашиглан төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг цахим хэлбэрт оруулах ажлын бэлтгэлийг хангалаа.
- Дүүргийн Соёлын ордон "Хотын соёл" аяны хүрээнд 7 хоног бүр "Бүжиг" арга хэмжээг зохион байгуулж тайлангийн хугацаанд 38 байгууллага хуваарийн дагуу арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 2300 гаруй иргэд оролцсон байна.
- "Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүрэгт мод тариалалтыг 2 удаа зохион байгуулж, 32 байгууллагын 520 албан хаагч 4370 мод, бут, сөөг тарьж 2.4 сая төгрөг зарцуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:* Тус дүүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон тэдгээртэй нийцүүлэн гаргасан заавар журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй ба Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан гарсан байна.

Дүүргийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Дотоод аудитын алба нь дүүргийн Засаг даргын баталсан 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу явцын 3, гүйцэтгэлийн 8 нийт 11 байгууллагад аудит хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр явцын 3, гүйцэтгэлийн 8,төлөвлөгөөт бус 2 нийт 13 байгууллагад давхардсан тоогоор 48 удаагийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, 24,125.1 мянган төгрөгийн 7 зөрчил илрүүлж 14 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 91.7 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлах итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багахангай дүүргийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл/мөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус дүүрэгт мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багахангай дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,487,471.3 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,081,057.2 | 751,018.0 | (330,039.2) |
| Авлага | 76,455.8 | 55,454.3 | (21,001.5) |
| Урьдчилгаа | 2,581.4 | 14,919.1 | 12,337.7 |
| Бараа материал | 618,819.5 | 600,783.4 | (18,036.1) |
| Үндсэн хөрөнгө | 15,831,353.7 | 13,700,621.6 | (2,130,732.2) |
| **Нийт хөрөнгө** | **17,610,267.6** | **15,122,796.3** | **(2,487,471.3)** |
| Өр төлбөр | 47,420.8 | 56,091.4 | 8,670.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 17,562,846.8 | 15,066,704.9 | (2,496,141.9) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **17,610,267.6** | **15,122,796.3** | **(2,487,471.3)** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Дээрх хүснэгтээс харахад 2,487,471.3 мянган төгрөгөөр өмнөх оны үзүүлэлтээс нэлээ бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь

оролцоо дансдууд байна. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж төсвийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу орон нутгийн төсвөөс улсын төсөвт 5 байгууллага шилжиж, хөрөнгө буурсан нь нөлөөлжээ.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 751,017.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 330,039.2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Банканд байгаа бэлэн мөнгө** | **1,081,057.1** | **751,017.9** | **(330,039.2)** |
| **Төгрөг** | **1,075,948.3** | **740,377.0** | **(335,571.3)** |
| Төрийн сангийн харилцах | 682,093.3 | 634,585.0 | (47,508.3) |
| Арилжааны банк дахь харилцах | 393,855.0 | 105,792.0 | (288,063.0) |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 5,108.8 | 10,640.9 | 5,532.1 |
| **Дүн** | **1,081,057.1** | **751,017.9** | **(330,039.2)** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 47,508.3 мянга, арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл 288,063.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг тайлант хугацаанд зарцуулснаас шалтгаалсан байна.
Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,532.1 мянган төгрөгөөр өссөн нь орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

*Аудитын илрүүлэлт:*

- Анхан шатны баримтын бүрдэлгүй, зохих шийдвэргүйгээр, зориулалт бусаар материалын үнэ нэрээр 2,000.0 мянган төгрөгийг төлсөн. */Багахангай тохижилт ОНӨААТҮГ/*
- Төлбөртэй үйлчилгээний орлогыг ерөнхий журнал, кассын дэвтэр, анхан шатны баримтад 853.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн */Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ /*
- 2016-2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гэрээнд тусгагдсан барьцаа чөлөөлөх хугацаа дууссанаас 1-ээс дээш жил өнгөрсөн, ээзн холбогдогч тодорхойгүй 2 иргэн аж ахуйн нэгжийн 829.2 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна. */БХД ДХО/*
- Гэрээгүй, үнийн харьцуулалтгүй 49,338.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. */Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ/*

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 55,454.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,001.5 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчтай холбогдсон авлага | 1,121.6 | 410.0 | (711.6) |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 58,854.5 | 54,842.4 | (4,012.1) |
| Байгууллагаас авах авлага | 16,479.7 | 201.9 | (16,277.8) |
| **Дүн** | **76,455.8** | **55,454.3** | **(21,001.5)** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны авлага цуглуулалт өссөнтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт*

- Тайлант онд 5,062.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. */БХД ДАА/*

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 14,919.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,337.7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 2,581.4 | 14,919.1 | 12,337.7 |
| **Дүн** | **2,581.4** | **14,919.1** | **12,337.7** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Урьдчилж гарсан зардал нэмэгдсэн нь ИТХ 12,000.0 мянган төгрөг, "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ 337.7 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардал бүртгэгдсэнтэй холбоотой байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 600,783.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,036.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **2,482.4** | **-** | **(2,482.4)** |
| Эм боох материал | 2,482.4 | - | (2,482.4) |
| **Хангамжийн материал** | **616,337.1** | **600,783.4** | **(15,553.7)** |
| Бичиг хэргийн материал | 18,490.0 | 14,802.9 | (3,687.1) |
| Аж ахуйн материал | 218,319.8 | 386,799.5 | 168,479.7 |
| Сэлбэг хэрэгсэл | 886.3 | 886.3 | - |
| Түлш, шатах тослох материал | 4,098.3 | - | (4,098.3) |
| Барилгын засварын материал | 5,482.0 | - | (5,482.0) |
| Хүнсний материал | 5,239.5 | | (5,239.5) |
| Бусад хангамжийн материал | 363,821.1 | 198,294.7 | (165,526.5) |
| **Дүн** | **618,819.5** | **600,783.4** | **(18,036.1)** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Тайлант онд 1 орон нутгийн өмчит газар (*Багахангай тохижилт, ногоон байгууламж ОНӨААТҮГ*) нэмэгдсэнээр бараа материалын үлдэгдэл өссөн болович бүтцийн өөрчлөлтөөр 5 ( *хангай цогцолбор сургууль, 44 дүгээр цэцэрлэг, 207 дугаар цэцэрлэг, ГБХЗХХ, БТСХороо*) байгууллагын 261,935.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсөвт шилжүүлсэн нь нөлөөлсөн.

*Аудитын илрүүлэлт*

- Бараа материалыг улирлаар өссөн дүнгээр тайлагнасан, ангилал тус бүрээр бүртгээгүй ,бусад хангамж, бичиг хэргийн материалын эхний үлдэгдлийг 5,738.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, ажилтнуудад ашиглаж байгаа 253.8 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна. */БХД ЗДТГ-5738.0 мянга, ЖДҮДТ-253.8 мянга /*

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 19,038,838.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,989,113.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **21,786,506.1** | **18,787,489.1** | **(2,999,017.0)** |
| Барилга, байгууламж, орон сууц | 15,873,075.9 | 11,145,225.3 | **(4,727,850.6)** |
| Авто-тээврийн хэрэгсэл | 2,307,065.1 | 2,098,364.8 | **(208,700.3)** |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 2,335,060.7 | 2,968,667.3 | **633,606.6** |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 559,469.9 | 277,263.2 | **(282,206.7)** |

| | | | |
|---|---|---|---|
| Бусад үндсэн хөрөнгө | 651,684.5 | 2,276,216.0 | **1,624,531.5** |
| Ном | 60,150.0 | 21,752.5 | **(38,397.5)** |
| **Биет бус хөрөнгө** | **241,445.5** | **251,349.1** | **9,903.6** |
| Программ хангамж | 28,836.7 | 22,362.7 | **(6,474.0)** |
| Бусад биет бус хөрөнгө | 212,608.8 | 228,986.4 | **16,377.6** |
| **Дүн** | **22,027,951.6** | **19,038,838.2** | **(2,989,113.4)** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Тайлант онд үндсэн хөрөнгө 5,014,325.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 8,003,438.5 мянган төгрөгөөр хорогдож, жилийн эцсийн үлдэгдэл 13,700,621.6 мянган төгрөг байгаа бөгөөд тайлант хугацаанд 1,594,801.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцогдож, акталсан болон шилжүүлсэн хөрөнгийн 2,453,182.8 мянган төгрөг хуримтлагдсан элэгдэл данснаас хасагдсан байна.

Тайлант хугацаанд 5,014,325.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэний 77,878.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 4,936,447.2 мянган төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалт, хандив тусламжаар бэлтгэсэн байна.

*Төсвийн хөрөнгөөр :*

- ЗДТГазар - 40,000.0 мянган төгрөг их засвар
- ИТХ – 12,670.5 мянган төгрөг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- ХААА- 2,500.0 төгрөг компьютер
- ДАА – 14,107.5 мянган төгрөг тавилга эд хогшил
- ЖДҮДТ – 7,500.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус худалдан авсан байна.

*Хандив тусламж, хөрөнгө оруулалтаар :*

- ЖДҮДТ-ийн барилга – 619,456.2 мянган төгрөг */улсын төсвийн хөрөнгө оруулалтаар/*
- ЗДТГазар - 1,628,269.8 мянган төгрөг */Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2-р хорооны замчин гэр хорооллын авто замаас өвөжих төвийн хаалдаа мянганы зам хүртэлх авто зам, дугуйн болон явган хүний зам/*
- ЗДТГ- 75,475.2 мянган төгрөгийн биет бус хөрөнгө */нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 71,875.2 мянган төгрөгийн өйн сан бүхий газар,3,600.0 мянган төгрөгийн усан бассейн, боулингийн төв барих газар/*
- Багахангай Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТ- 800,501.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр */Хот тохижилтын алба ОНӨААТҮГ-аас шилжүүлэн авсан хөрөнгө/* тус тус нэмэгджээ.

*Хасагдсан хөрөнгө 8,003.438.5 мянган төгрөг:*

Үүнд:

- Бүтцийн өөрчлөлтөөр 5 байгууллага улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор 6,404,330.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг */хуримтлагдсан элэгдэл 1,286,575.9 мянган төгрөг, үлдэх өртөг 5,117,754.2 мянган төгрөг/* шилжүүлсэн.

- Актласан хөрөнгө - 414,832.5 мянган төгрөг */Холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрлийн дагуу 7 байгууллага - ЗДТГ, Соёлын ордон, ХААА, ЖДҮДТ- ОНӨБ-3/*

*Аудитын илрүүлэлт:*

- Тоног төхөөрөмжийн ашиглах жилийг буруу тооцсоноос элэгдлийн зардлыг 16.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. */БХД ЗДТГ/*

### 3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 56,091.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,670.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Өглөг** | 9,846.6 | 14.3 | (9,832.2) |
| Ажилчидтай холбоотой өглөг | - | 14.3 | 14.3 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 9,846.6 | - | (9,846.5) |
| **Бусад өглөг** | 36,331.3 | 55,757.8 | 19,426.5 |
| Байгууллагад төлөх өглөг | 14,047.7 | 27,792.8 | 13,745.1 |
| Татварын өглөг | 22,283.6 | 26,417.8 | 4,134.2 |
| НДШ-ийн өглөг | - | 4.3 | 4.3 |
| Дансны өглөг | - | 1,542.8 | 1,542.8 |
| **Урьдчилж орсон орлого** | 1,243.0 | 319.3 | (923.7) |
| Бусад урьдчилж орсон орлого | 1,243.0 | 319.3 | (923.7) |
| **Дүн** | **47,420.8** | **56,091.4** | **8,670.6** |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Өглөгийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь 2022 онд хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын барьцаа чөлөөлөлтийн хугацаа дуусаагүй, барьцааны өглөг өссөнтэй холбоотой байна.

Урьдчилж орсон орлого буурсан нь "Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ-ын орлого багассанаас шалтгаалжээ.

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 15,066,704.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,496,141.9 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,114,642.8 | 2,115,911.0 | (1,998,731.8) |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 4,996,866.1 | 6,441,015.0 | 1,444,148.9 |
| Өздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 133,425.6 | 162,060.1 | 28,634.5 |
| **Хуримтлагдсан үр дүн** | **2,746,333.7** | **2,848,254.6** | 101,920.9 |
| Өмнөх үеийн үр дүн | 2,830,735.4 | 6,810,455.0 | 3,979,719.6 |
| Тайлант үеийн үр дүн | (84,401.7) | (3,962,200.4) | (3,877,798.7) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,571,578.6 | 3,499,464.2 | (2,072,114.3) |
| **Дүн** | **17,562,846.8** | **15,066,704.9** | (2,496,141.9) |

*Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"*

Засгийн газрын хувь оролцоо данс 2,496,141.9 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн төсвөөс улсын төсөвт 5 байгууллага шилжсэнээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,406,970.1 мянга, үйл ажиллагааны орлогоос 8,900.0 мянга, нийт зарлагыг 6,415,870.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 1,073,613.9 мянган төгрөгөөр бууруулж 5,342,256.2 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь 2022 төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалжээ.

### 3.5.2. Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын "Дүүргийн 2022 оны төсөв батлах тухай" 2021 оны 12 дугаар сарын 17-ны А/06 дугаар тогтоолоор анх дүүргийн татварын болон татварын бус орлогыг 1,232,711.5 мянга, нийслэлийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 3,747,728.2 мянга, нийслэлийн ОНХС-аас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 267,063.0 мянга, төсвийн урьд оны үлдэгдлээс 80,164.5 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 14,589.0 мянга

нийт 5,342,256.2 мянган төгрөгөөр, үүнээс төсвийн нийт зарлагыг 5,342,256.2 мянган төгрөгөөр төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан Дүүргийн ИТХ-ын "Дүүргийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" А/23 дугаар тогтоолоор дүүргийн татварын болон татварын бус орлогыг нийт 1,032,877.7 мянга, нийслэлийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 3,745,381.6 мянга, нийслэлийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 243,349.9 мянга, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 14,132.1 мянга, дүүргийн төсвийн урьд оны үлдэгдлээс 576,430.1 мянга, төсвийн байгууллагын өөрийн орлого 19,069.4 мянга, нийт 5,631,240.8 мянган төгрөгөөр, үүнээс төсвийн нийт зарлагыг 5,631,240.8 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд 1,051,947.1 мянган төгрөгийн урсгал */татварын болон татварын бус/* орлогыг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 1,245,110.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 118 хувиар биелүүлжээ.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Нэр төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН/III+IV/** | **1,051,947.2** | **1,245,110.1** | **-193,162.9** | **118.4** |
| **ТАТВАРЫН ОРЛОГО** | **757,556.6** | **995,177.3** | **-237,620.7** | **131.4** |
| **1.ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ДҮН** | **617,572.6** | **879,786.5** | **-262,213.9** | **142.5** |
| Хувь хүний орлогын албан татвар | 1,600.0 | 8,007.1 | -6,407.1 | 500.4 |
| Цалин хөлс болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 551,372.6 | 685,936.5 | -134,563.9 | 124.4 |
| Иргэдийн хадгаламжийн хүүгийн татвар | 32,000.0 | 29,791.3 | 2,208.7 | 93.1 |
| Бичил үйл ажиллагааны орлого | 14,600.0 | 119,597.3 | -104,997.3 | 819.2 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 18,000.0 | 36,454.3 | -18,454.3 | 202.5 |
| **Өмчийн татвар** | **66,000.0** | **34,967.4** | **31,032.6** | **53.0** |
| Бууны албан татвар | 1,000.0 | 1,105.5 | -105.5 | 110.6 |
| малд ногдуулах татвар | 5,000.0 | 5,484.8 | -484.8 | 109.7 |
| үл хөдлөх хөрөнгийн татвар | 60,000.0 | 28,377.1 | 31,622.9 | 47.3 |
| **Бусад татвар** | **73,984.0** | **80,423.4** | **-6,439.4** | **108.7** |
| Улсын тэмдэгтийн хураамж | 11,250.0 | 3,954.4 | **7,295.7** | **35.1** |
| Газрын төлбөр | 40,734.0 | 52,207.9 | -11,473.9 | **128.2** |
| Хог хаягдлын хураамж | 20,000.0 | 21,715.2 | -1,715.2 | **108.6** |
| Ус, ашигласны төлбөр | 2,000.0 | 2,546.0 | -546.0 | **127.3** |
| **Татварын бус орлого** | **294,390.6** | **249,932.9** | **44,457.7** | **84.9** |
| Хүү торгуулийн орлого | 249,021.2 | 197,317.8 | 51,703.4 | 79.2 |
| Ангилагдаагүй бусад орлого | 26,300.0 | 36,638.0 | -10,338.0 | 139.3 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 19,069.4 | 15,977.1 | 3,092.3 | 83.8 |

*Төлөвлөгөө давж биелсэн орлогын төрлүүдийн хувьд:*

*Бичил үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого* нь өмнөх оны өр барагдсанаас, *цалин хөлс болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого* нь тайлант оны ногдлыг төвлөрүүлсэн, цалин нэмэгдсэнээс, *хөрөнгө борлуулсны орлого* нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор иргэд үл хөдлөх хөрөнгөө борлуулах нь ихэссэнээс, *хог хаягдлын хураамж* нь дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагууд хугацаандаа хураамжаа төлснөөс, *газрын төлбөр* нь ногдлыг тухай бүр төлүүлж өмнөх жилийн төлөлт хийгдсэнээс, *малын албан татвар* нь малчид ноолуур болон мах зарах үеэр татвараа төлснөөс, *татварын алданги, торгуулийн орлого* нь татварын хяналт шалгалтын өр төлбөрийг бүрэн барагдуулснаас, *хувь хүний орлогын албан татвар* нь татвар төлөгчдийн татварын тайлангаар ногдсон хувьцааны ногдол ашгийг төлүүлснээс тус тус төлөвлөгөө давж биелсэн байна.

*Төлөвлөгөө тасарч буй орлогын төрлүүдийн хувьд:*

*Үл хөдлөх эд хөрөнгийн татвар, улсын тэмдэгтийн хураамж* нь дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг татвар төлөх байгууллага бага ногдлоор төлөлт хийгдэж төлөвлөгөө өндөр тавигдсанаас, хүү торгуулийн орлого нь цагдаагийн байгууллагын торгуулийн төлөлт бага байснаас, *төсөвт байгууллагын өөрийн орлого* нь ЖДҮДТ-ийн түрээсийн орлого тасарснаас шалтгаалжээ.

### 3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 288,684.6 мянган төгрөгөөр *нэмэгдүүлж* тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 257,482.0 мянга, нийслэлийн төсвөөс 3,745,381.6 мянга, дүүргийн төсвөөс 1,609,307.8 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 19,069.4 мянга, нийт 5,631,240.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 257,482.0 мянга, нийслэл,дүүргийн төсвөөс 3,745,381.6 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 15,977.1 мянга, нийт 5,628,148.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,322,893.0 мянган төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 269,556.4 мянга, хөрөнгийн зардлыг 38,791.4 мянга, нийт 308,347.8 мянга төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70105.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | 661,635.4 | 623,202.9 | -38,432.5 | 94.2 |
| 2 | 70106.Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 1,597,156.9 | 1,414,578.6 | -182,578.3 | 88.6 |
| 3 | 70418. Худалдан авах ажиллагаа | 112,170.5 | 108,437.5 | -3,733.0 | 96.7 |
| 4 | 70429.Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага | 169,764.4 | 161,230.1 | -8,534.3 | 94.9 |
| 5 | 72101.ЖДҮ-ийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох | 160,593.0 | 155,668.1 | -4,924.9 | 96.9 |
| 6 | 70901.Дулаан цахилгаан эрчим хүч | 710,323.1 | 710,323.1 | 0 | 100.0 |
| 7 | 71502.Хот байгуулалт, тохижилт | 572,866.3 | 572,886.3 | 0 | 100.0 |
| 8 | 71508.Гудамжны гэрэлтүүлэг | 260,000.0 | 260,000.0 | 0 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 71702.Соёл урлаг | 277,405.7 | 267,815.8 | -9,589.9 | 96.5 |
| 10 | 71802.Ерөнхий боловсрол | 220,081.2 | 219,270.0 | -811.2 | 99.6 |
| 11 | 71801.Сургуулийн өмнөх боловсрол | 156,822.6 | 149,971.1 | -6,851.5 | 95.7 |
| 12 | 70601. Орон нутгийн төсвөт олгох шилжүүлэг | 262,482.0 | 250,123.3 | -12,358.7 | 95.3 |
| 13 | 70106. Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 390,164.5 | 351,373.1 | -38,791.4 | 90.1 |
| 14 | 71701.Биеийн тамир спорт | 79,775.2 | 78,032.9 | -1,742.3 | 97.9 |
| | **Нийт дүн** | **5,631,240.8** | **5,322,893.0** | **-308,347.8** | **94.5** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт эх үүсвэрээр ИТХ 170,000.0 мянга, ЗДТГ 40,885.8 мянга, Соёлын ордон 1,500.0 мянга, нийт 212,385.8 мянган төгрөгийг авч холбогдох шийдвэр журмын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 169,924.4 мянга, соёлын арга хэмжээний зардалд 1,500.0 мянга, унааны нөхөн олговор, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, өвс тэжээл худалдан авах, шагналын зардалд 36,035.0 мянга, нийт 207,459.4 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 4,926.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын 2022 оны "Дүүргийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" А/23 дугаар тогтоолоор 2022 онд хэрэгжих 22 төсөл, арга хэмжээний нийт 390,164.5 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр баталжээ.

Хөрөнгө оруулалтын 22 төсөл, арга хэмжээнд нийт 390,164.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд 321,370.0 мянга, техник хяналтын зардалд 2,424.1 мянга, барьцаа дансанд 24,285.7 мянга, зохиогчийн хяналтын зардалд 1,071.7 мянга, алданги 599.1 мянга, магадлашгүй ажлын зардал 1,622.5 мянга нийт 351,373.1 мянган төгрөгийг олгож, дүүргийн ерөнхий орлогын дансанд 38,791.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэлгүй тайлагнасан байна.

**<u>ОНХС-ийн хөрөнгө оруулалт:</u>**

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын 2022 оны "дүүргийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" А/23 дугаар тогтоолоор он дамжсан 1 төсөл, арга хэмжээний нийт 14,132.1 мянга, 2022 онд хэрэгжих 11 төсөл, арга хэмжээний

248,349.9 мянга, нийт 262,482.0 мянган төгрөгийг төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр нийслэлийн ОНХС-ийн эхний үлдэгдэл 9,491.4 мянга, тайлант онд 262,482.0 мянган төгрөгийн орлого орсноос гүйцэтгэгч байгууллагад 229,225.0 мянга, барьцаа дансанд 11,541.1 мянга, техник хяналтын зардалд 2,942.5 мянга, зохиогчийн хяналтын зардалд 1,471.2 мянга, алданги 2,001.0 мянга, магадлашгүй ажлын зардал 2,942.5 мянга, нийт 250,123.3 мянган төгрөгийг зарцуулж, 21,850.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Нийт барьцаа хөрөнгө:**

Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 17,181.9 мянган төгрөг байснаас 42,318.8 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 29 төсөл, арга хэмжээнд нийт 9,375.8 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж, оны эцэст 40 төсөл, арга хэмжээний 50,124.9 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**3.5.6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Нийслэлийн Багахангай дүүргийн ОНӨААТҮГ-ууд нь 2022 онд нийт 2,114,688.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 2,655,082.1 мянган төгрөгийг зарцуулж, 510,393.4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Орлого өмнөх оныхоос 12,007.6 мянган төгрөгөөр буурч, зардал 296,457.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гол нөлөө үзүүлсэн байна.

Дүүргийн ЗД-ын баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 2,093,896.6 мянган төгрөг буюу 102.4 хувиар биелүүлсэн, зардал 2,914,843.9 мянган төгрөг буюу 91.1 хувиар дутуу зарцуулжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материал, үндсэн хөрөнгийг үнэн зөв бүртгэж тайлагнах, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, авлага, өглөгийг тухай бүр тооцоо нийлж, актаар баталгаажуулах, төсвийг үр ашигтай зөв удирдаж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, зардлын тооцооллыг үнэн зөв хийх, шилэн данс, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн аудитор Д.Нарантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг дарга дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/171 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 8,731,745.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 174,634.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 139,707.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой тус дүүрэг нь 2022 онд төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 5,631,240.8 мянган төгрөг байхаас гүйцэтгэлээр

5,322,893.0 мянган төгрөгийг зарцуулж, 308,347.8 мянган төгрөг хэмнэж ажилласан байна. Үүнд: орон нутгийн төсвийн байгууллагаас 299,642.8 мянган төгрөг, улсын төсвийн байгууллагад олгосон байр ашиглалтын зардал 8,705.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна .

Цалингийн зардал хэмнэгдсэн нь орон тоо дутуу ажилласан, бүтэц орон тоог өмнөх оноос нэмэгдүүлээгүйгээс шалтгаалжээ.

Байр ашиглалттай холбоотой зардал хэмнэгдсэн нь тайлант онд урсгал засвар болон их засварын ажил хийгдэж дулаан, цахилгаан цэвэр бохир усны зардал багассан нь нөлөөлсөн байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.,14.4. дэх заалтыг зөрчиж 18,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. */БХД-ийн ЗДТГ/*

*__Шийдвэрлэсэн нь__*: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Багахангай дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь 2022 онд нийт 313,621.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг бүрэн байршуулсан байна.

1.Санал дүгнэлт гаргасан 4 шалгагдагч байгууллага нь 2022 онд нийт 2,269,023.3 мянган төгрөгийн 458 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,072,197.4 мянган төгрөгийн мэдээллийг дутуу, 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд 5 саяас төгрөгөөс дээших үнийн дүн бүхий 132,688.1 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээг дутуу, 1 мэдээллийг

хугацаа хоцроож байршуулсан байна. */БХД ЗДТГ-132,688.1 мянга, Багахангай тохижилт ОНӨААТҮГ/*

- Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий 939,529.3 мянган төгрөгийн 33 мэдээллийг хугацаа хоцроосон байна. /Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ- 939,529.3 мянган төгрөг/

Эдгээр зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.*"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;"*, 6 дугаар зүйлийн 6.4.*"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:"*, 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.3.7. "хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

*__Шийдвэрлэсэн нь:__* 1 байгууллагад зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, 2 байгууллагад зөвлөмж өгч ажиллалаа.

2.Аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн (*түүвэрт хамруулсан*) 4 шалгагдагч байгууллага нь 704,729.2 мянган төгрөгийн 476 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг бүрэн байршуулсан байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд гэрээгүй, үнийн харьцуулалтгүй 49,338.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.*/Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ/*

*__Шийдвэрлэсэн нь:__* Шалгагдагч байгууллагад зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус дүүргийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 14,123.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад бараа материалын тайланг зөрүүтэй илэрхийлсэн, шилэн дансны мэдээлэл дутуу зэрэг зөрчил давтагдан гарсан тул зөвлөмж өгсөн.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,162.3 мянган төгрөгийн 3 акт, 12,752.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 25,238.3 мянган төгрөгийн 22 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт*, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 3 | 1,162.3 | 3 | 1,162.3 | 100 |
| Албан шаардлага | 2 | 12,752.5 | 2 | 12,752.5 | 100 |
| Зөвлөмж | 22 | 25,238.3 | 22 | 25,238.3 | 100 |
| **Нийт дүн** | **27** | **39,153.1** | **27** | **39,153.1** | **100** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар түрээсийн орон сууцны орлого төвлөрүүлэлт, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйл ажиллагаа, орон нутгийн өмчит компаниудын эдийн засгийн зорилтод түвшинг үндэслэлтэй баталдаг эсэх, удирдлагын менежментийг оновчтой хэрэгжүүлж байгаа эсэх, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт сонгон шалгаруулалт хийдэг эсэх, хөрөнгө оруулалт, орон нутгийн орлогыг хэрхэн оновчтой төлөвлөж байгаа зэргийг үзэх болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 13 байгууллага аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 6 байгууллага */ИТХ, ЗДТГ, ЖДҮДТ, ХААА, ДАА, Соёлын ордон /*, 4 сан, зардал */ОНХС, Хөрөнгө оруулалтын бэрцээ, дүүргийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах сан, Ахмадын хороо /*, аж ахуйн тооцоотой 3 байгууллага */ "Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ, "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ, "Багахангай эрэлтүүлэг,ногоон байгууламж" ОНӨААТҮГ /*-ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| № | Байгууллагын ангилал | НТАГ-аас дүгнэлт гаргасан | Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан | Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн | Аудитад хамрагдаагүй |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТШЗ | 2 | | 8 | |
| 2 | ОНӨААН | | 2 | 1 | |
| | **Дүн** | **2** | **2** | **9** | |

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" 3 *(БХД-ийн ИТХ, "Багахангай тохижилт "ОНӨААТҮГ, "Багахангай Илч-Орд" ОНӨААТҮГ)* "Хязгаарлалтай" 1 (*БХД-ийн ЗДТГ*) санал дүгнэлт өглөө.

### 5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар нийт 457,675.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 450,517.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,158.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалыг 5,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. *(ТТЗ)*
- ОНХС-аас 61,345.5 мянга, дүүргийн хөрөнгө оруулалтаас 134,671.3 мянган төгрөгийн зураг төсвийг бүртгэлээс хассан. *(БХД-ийн ХО,ОНХС)*
- Бараа материалын тодруулга тайланд 10,963.4 мянган төгрөгийн орлого, зардлыг илүү тайлагнасан. *(БХД-ийн ИТХ)*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү болох 1,833.9 мянган төгрөгийг дутуу тайлагнасан. *(БХД-ийн ХАА)*
- Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг 21,607.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. */БХД-ийн ДАА-14,107.5 мянга, ЖДҮДТ 7,500.0 мянга/*
- Мөнгөн гүйлгээний тайланд 7,377.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг дутуу тайлагнасан. */БХД-ийн ОНХС/*
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. */БХД-ийн ЗДТГ/*
- Элэгдлийн зардлыг 579.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 10.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. */БХД-ийн ЖДҮДТ/*
- Менежмент ба ур чадварын хүрээлэнд 12,000.0 мянган төгрөгийн сургалтын зардал шилжүүлснийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй байна. */БХД-ийн ИТХ/*
- Байгууллагын эзэмшлийн 194,128.8 мянган төгрөгийн өртөг бүхий 5 газрыг бүртгэж тайлагнаагүй. */Багахангай Иль-Орд ОНӨААТҮГ/*

Аудитаар нийт 97,878.1 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 7,393.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 75,389.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 15,094.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

**5.1.1. Орон нутгийн байгууллага**

Аудитаар нийт 65,027.3 мянган төгрөгийн зөрчил[3] илэрснээс, 829.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 59,135.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 5,062.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

**1.Төлбөрийн акт**

1.1 2016-2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа чөлөөлөх хугацаа дууссан, эзэн холбогдогч тодорхойгүй 2 иргэн аж ахуйн нэгжийн 829.2 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7".*Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.*"заалтыг зөрчиж байна. */БХД ДХО/*

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**2 Албан шаардлага**

2.1 Ажилтнуудад нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 28,957.6 мянган төгрөгийн шагнал, урамшуулал, 3,023.1 мянган төгрөгийн тусламж дэмжлэг, зөвлөхийн орон тоо ажиллуулж 18,596.6 мянган төгрөгийн цалин олгож төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"*төсвийг үр ашигтай,*

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" заалтыг зөрчсөн байна */БХД-ийн ЗДТГ-47.554.2 мянга, ДАА-3023.1 мянга /*

2.2.Засаг даргын нөөц хөрөнгөөс жил бүр болдог санхүүчдийн өдөр, архивчдын өдөр, багш нарын баяр зэрэг тэмдэглэлт өдрийн арга хэмжээнд 7,558.0 мянга, ЗДТГ-ын 2 ажилтанд буцалтгүй тусламж 1,000.0 мянга, нийт 8,558.0 мянган төгрөгийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой зардлыг санхүүжүүлсэн нь Сангийн сайдын баталсан 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 " *энэ журмын 2.1.1,2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ*" заалттай нийцэхгүй байна. */БХД-ийн ЗДТГ/*

*__Шийдвэрлэсэн нь__*: Дээрх зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

### 5.1.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд

Аудитаар нийт 32,850.8 мянган төгрөгийн зөрчил[4] илэрснээс, 6,564.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 16,254.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 10,032.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**1.Төлбөрийн акт**

1.1 Автомашины шатахууны тооцоолол хянан тулган шалгахад 4,224.5 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019.12.30-ны өдрийн жишиг норм батлах 390-р тушаалыг мөрдөөгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.1.*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Багахангай Илч Орд ОНӨААТҮГ/

1.2 Анхан шатны баримтын бүрдэлгүй, зохих шийдвэргүйгээр, зориулалт бусаар материалын үнэ нэрээр 2,000.0 мянган төгрөгийг Таван мичид" ХХК-д шилжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5."*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. */Багахангай тохижилт ОНӨААТҮГ/*

1.3 Ажилтнуудын цалинг тулган шалгахад 2 ажилтанд 339.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон *нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" заалтыг зөрчсөн байна */Багахангай гэрэлтүүлэг,ногоон байгууламж ОНӨААТҮГ/*

*__Шийдвэрлэсэн нь:__* Дээрх зөрчлүүдэд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

**2.Албан шаардлага**

2.1 Төлбөртэй үйлчилгээний орлогыг ерөнхий журнал, кассын дэвтэр, анхан шатны баримтад 853.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн

---

[4] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид заасан байгууллага, түүний удирдлага, байгууллагын ажилтан бусад хүн хуулийн шаардлагыг биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүй.

тухай хуулийн 20.2.5".*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. */Багахангай Илч Орд ОНӨААТҮГ/*

2.2 Захиргаа хүний нөөц, бичиг хэргийн болон санхүүгийн ажилтнуудад 10,401.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг үндэслэлгүй тооцоолон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "*Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй,*"заалт, 5.1.2 "*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;*"заалтыг зөрчсөн байна. */Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ/*

2.3 Нийслэлийн Багахангай дүүргийн засаг даргын захирамж үндэслэн Турк улс руу аяллаар явахад зориулж 5,000.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан нь Засгийн газрын 388-р тогтоолын 2.3 "*төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл арга хэмжээг тусгахгүй байх*", 5.4"... *зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт өй, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, тус тус хэмнэх чиглэл баримтлах*", Төсвийн тухай хуулийн 16.5.5"*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;*" 6.4.1."*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. */Багахангай тохижилт ОНӨААТҮГ/*

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Дээрх зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагыг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

## 5.2 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүн

Аудитаар нийт 5,000.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад алдааг залруулж, дотоод хяналтыг сайжруулах 1 зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалыг 5,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. *(ТТЗ)*

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 5.2.1 Бараа материалын данстай холбоотой асуудал:

*<u>1 Илрүүлэлт:</u>* Бараа материалыг улирлаар өссөн дүнгээр тайлагнасан, ангилал тус бүрээр бүртгээгүй, бусад хангамж, бичиг хэргийн материалын эхний үлдэгдлийг 5,738.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, ажилтнуудад ашиглаж байгаа 253.8 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх;"заалтыг зөрчиж байна. */БХД ЗДТГ-5738.0 мянга, ЖДҮДТ-253.8 мянга /*

*<u>2 Өгсөн зөвлөмж</u>:* Бараа материалыг үнэн зөв тайлагнах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

### *5.2.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:*

<u>*1. Илрүүлэлт:*</u> Хөрөнгийн ашиглах жилийг буруу тооцсоноос 16.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *"үнэн зөв байх"* заалттай нийцэхгүй байна. */БХД-ийн ЗДТГ/*

<u>*2 Өгсөн зөвлөмж:*</u> Хөрөнгийн бүртгэлийг зөв хөтлөх, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

### *5.2.3 Авлага,өглөгийн данстай холбоотой асуудал:*

<u>*1 Илрүүлэлт:*</u> Тайлан онд 5,062.8 мянган төгрөгийг байгууллагуудтай тооцоо нийлээгүй нь хэрэглэгчид хүрэх санхүүгийн мэдээлэл зөрүүтэй байх эрсдэлд хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн *20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* заалттай нийцэхгүй байна. /БХД ДАА/

<u>*2 Өгсөн зөвлөмж:*</u> Авлага, өглөгийг тухай бүр тооцоо нийлж, тооцоо бодсон актаар баталгаажуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах;

### 5.2.4 Зардлын данстай холбоотой асуудал:

<u>*1.Илрүүлэлт:*</u> Автомашины шатахууны тооцооллыг хянан тулгахад 1,150.0 мянган төгрөгийн шатахуун илүү тооцсон, ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглахгүй байгаа автомашинд 10,032.1 мянган төгрөгийн шатахуун олгосон байна. */Багахангай тохижилт ОНӨААТҮГ-1150.0 мянга, Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ-10,032.1 мянга/*

Эдгээр зөрчлүүд нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ны өдрийн "Жишиг норм батлах" тухай 390 дүгээр тушаалын 2-р хавсралтад заасан заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, 4.1.3 *"үр ашигтай байх"*, 4.1.9 *"хариуцлагатай байх"* гэх заалтуудыг зөрчсөн байна.

<u>*2.Өгсөн зөвлөмж:*</u> Төсвийг үр ашигтай зөв удирдаж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, зардлын тооцооллыг үнэн зөв хийх;

### 5.2.5.Тайлагналтай холбоотой асуудал:

<u>*Илрүүлэлт:*</u> Санхүүгийн тайлангийн тодруулгыг үнэн зөв бодитойгоор бэлтгэж тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2. *"Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь энэ хуулийн 16.1-д заасан этгээдийн шаардсан тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө"* заалттай нийцээгүй байна. /Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ/

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаң санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэн, үнэн зөв бүртгэж тайлагнадаг байх;

### *5.2.6 Дотоод хяналттай холбоотой асуудал*

<u>*1.Илрүүлэлт:*</u> Дүүргийн харьяа байгууллагууд бараа материалыг зөрүүтэй бүртгэж тайлагнасан, цалин, урамшуулал, шатахууныг илүү дутуу тооцож олгосон, төсвийг үрэлгэн зориулалт бус зарцуулсан, шилэн дансны холбогдох хууль, заавар журмын мөрдөөгүй зэрэг өмнөх онд гарсан зарим зөрчлүүд давтан гарч байна.

***2.Өгсөн зөвлөмж:*** Дүүргийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.